⁵ The Washington Group on Disability Statistics is a UN city group established under the UN Statistical Commission. The Washington Group on Disability Statistics was constituted to address the urgent need for cross-nationally comparable population-based measures of disability. Its mandate is the promotion and coordination of international cooperation in the area of health statistics focusing on disability data collection tools suitable for censuses and national surveys.

I. УДИРТГАЛ

1. 2016 онд батлагдсан Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлийн орчин үеийн дэвшилтэт тодорхойлолтыг тусгаж, хязгаарлагдмал цар хүрээтэй анагаах ухааны уламжлалт тодорхойлолтоос татгалзсан. Тухайлбал, ХБИ гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно хэмээн заасан. Гэвч бодит амьдралд хөгжлийн бэрхшээлийг явцуу хүрээнд хардаг буруу ойлголт түгээмэл хэвээр байна.
2. ХБИ-ийн талаарх статистикийн мэдээлэл хомс байна.¹ Тухайлбал, статистикийн эх сурвалжид Монгол Улсын ХБИ-ийн тоо 2015 оны байдлаар 100,000 болон 118,000 байгаа буюу нийт хүн амын 4 орчим хувь байна гэсэн зөрүүтэй тайлан байдаг.² Үүнтэй харьцуулбал, дэлхийн нийт хүн амын 15.3 хувийг ХБИ эзэлдэг гэсэн тоо бий.³ Монгол Улсын статистикийн тайлангуудаас харахад, тэтгэврийн насны хүн амын бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувь хэмжээ буурч, эмэгтэйчүүдийг бодвол эрэгтэйчүүдийн дунд энэ хувь хэмжээ эрс өндөр байна. Гэтэл олон улсын статистикаас харвал нас ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувь хэмжээ нэмэгдэж, хүйсийн ялгаа төдийлөн илэрдэггүй ба илэрвэл эмэгтэйчүүдийн дунд илүү өндөр байж, энэ нь эмэгтэйчүүд илүү урт насалдагтай холбоотой байдаг. Монгол Улсын энэ үзүүлэлт дэлхийн зарим улс оронд давтагдаж байгаа нь ашиглаж байгаа хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолттой холбоотой байх талтай. Хөгжлийн бэрхшээлийн бүртгэл нийгмийн тэтгэмжтэй холбоотой байдаг тул тэтгэврийн насны бүлэгт энэ статистик буурсан байж болзошгүй. Түүнчлэн, эрэгтэйчүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй болсноор “эр хүний” хэмээгдэх уламжлалт ажил хийх чадваргүй болж, албан ёсоор бүртгүүлэх нь илүү түгээмэл байж болох юм. Эмэгтэйчүүдэд илүү элбэг тохиолддог зарим хөгжлийн бэрхшээл бүртгэл тайлагналд дутуу хамрагддагтай ч мөн холбоотой.
3. Нийт хүн амтай харьцуулахад ХБИ илүү их саад бэрхшээлтэй тулгардаг. Нэг болон түүнээс олон ХБИ-тэй Монгол өрхүүдийн хувьд ядуурлын түвшин ХБИ-гүй өрхүүдээс хоёр дахин өндөр байна. Хөдөлмөрийн насны ХБИ-ийн 70 хувь нь ажилгүй байхад хөгжлийн бэрхшээлгүй хөдөлмөрийн насны иргэдийн 36 хувь нь ажил эрхлэхгүй байна. 6-18 насны бүлгийг авч үзвэл, хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн 4 хувь, харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд (ХБХ)-ийн тэн хагас нь бичиг үсэг тайлагдаагүй байна. 3-5 насны ХБХ-ийн

¹ Бүх өгөгдлийг дараах тайлангаас авсан болно: АХБ. 2019 (удахгүй нийтлэгдэнэ). *Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэд: Оролцоог хангахад гарч буй ахиц дэвшил*. Манила. Тус тайланг боловсруулахад Япон Улсын Засгийн газар томоохон дэмжлэг үзүүлсэн ба Оксфорд Полиси Менежмент, Хүүхдийн төлөө түншлэл болон Хүн амын сургалт, судалгааны төв судалгааг гүйцэтгэсэн болно.

² ХБИ-ийн талаар мэдээлэл цуглуулдаг байгууллагууд харилцан адилгүй тодорхойлолт, аргачлал ашиглаж байгаа тул тооцоо судалгаа зөрүүтэй байна.

³ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага ба Дэлхийн банк групп. 2011. *Хөгжлийн бэрхшээлийн тухай дэлхийн тайлан*. Женев хот.

Integrating Persons with Disabilities into Mongolia's Society

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах нь

гуравны хоёр нь буюу 64 хувь нь цэцэрлэгт хамрагдаагүй байхад хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт гуравны нэг буюу 32 хувь байна.

4. Чухал ач холбогдолтой хууль тогтоомж албан ёсоор батлагдсан нь томоохон ахиц дэвшил болсон хэдий ч энэ нь Монгол Улс дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог автоматаар хангахгүй юм. ХБИ-ийг ардаа орхилгүй, тэдний бүхий л чадвар боломжийг бүрэн ашиглах нөхцөл бүрдүүлэхийн тулд олон нийтийн кампанит ажил, төрийн цогц бодлогоор Монголын нийгмийн сэтгэлгээг өөрчлөх шаардлагатай байна. Үүнд хөдөлмөр эрхлэлт, хүн амын насжилт, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээ зэрэг олон салбар дахь бодлогын арга хэмжээ шаардагдана. Хууль эрх зүйн дэвшилтэт орчинтой улсаас нийгмийн өдөр тутмын амьдралд ХБИ нийтээрээ бүрэн хамрагдсан улс болон шилжих Монгол Улсын хөгжлийн явцыг түргэсгэхийн тулд дараах хэсэгт танилцуулсан асуудлуудын мөн чанарт дүн шинжилгээ хийж, бодлогын үр дүнтэй хариу арга хэмжээ авах нь чухал. Үүн дээр үндэслэн, цаашид хэрэгжүүлбэл зохих зөвлөмжүүдийг энэхүү бодлогын товч танилцуулгад толилуулж байна.

II. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ: БОДЛОГЫН СОРИЛТ

5. **Хөгжлийн бэрхшээлийг хэт явцуу тодорхойлдгоос зарим төрлийн хөгжлийн бэрхшээл тусламж үйлчилгээнд хамрагдахгүй байна.** Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэвшилтэт үзэл бодол болон уламжлалт нийгмийн сэтгэлгээ буюу буруу ойлголтын хооронд ихээхэн зөрчил оршсоор байна. Бодит амьдралд хөгжлийн бэрхшээлийг голлон анагаах ухааны эмгэг хэмээн ойлгож, нийгмийн тэтгэмж авах тохиолдолд л бүртгэж, тайлагнаж байна. Үүнд хамрагдахгүй байсаар ирсэн нэг бүлэг бол сэтгэцийн ужиг эмгэг болон оюуны бэрхшээлтэй хүмүүс юм. Оюуны бэрхшээл болон сэтгэцийн эмгэгийг хооронд нь хольж хутган, сэтгэл мэдрэлийн бэрхшээл хэмээн хамруулан ойлгох байдал түгээмэл байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд (ХБИБ) ихэнх тохиолдолд оюуны бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлдөггүй бөгөөд тэдний эрхээ хамгаалуулах шаардлага хэрэгцээнд дэмжлэг олддоггүй байна.

6. **Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн үнэлгээний тогтолцоо төлөвшөөгүй ба ялангуяа хүүхдүүд дутуу хамрагдаж байна.** Монгол Улсад хөгжлийн бэрхшээлийг өвчин эмгэгтэй холбож ойлгодог тул бүх ХБИ хөгжлийн бэрхшээлээ бүртгүүлж, холбогдох эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахын тулд эмчээр оношлуулах шаардлага гардаг. Гэтэл нийт ХБИ-ийн хагаст нь л өрхийн эмч гэрт очиж үзлэг хийж байсан гэсэн судалгаа байдаг. Үүний улмаас, нийт ХБИ-ийн 30 хувь нь хөгжлийн бэрхшээлийг албан ёсоор оношлон бүртгэх эхний алхам хийгддэг ахисан шатны эмнэлэг рүү илгээх бичиг огт авч байгаагүй байна. Түүнчлэн, Монгол Улсын хувьд хөгжлийн бэрхшээлийн ангилал, үнэлгээг голлон насанд хүрэгчдэд хийдэг. Хөгжлийн саатлыг эрт оношилж, хүүхдийг бага насанд нь хөгжүүлэх

эмчилгээнд⁴ хамруулдаг тогтолцоо нэвтрүүлэх зорилгоор хүүхдийн хөгжлийн оношилгоог сайжруулах төлөвлөгөөнүүд боловсруулсан хэдий ч 18-аас доош насны гурван ХБХ-ийн нэг нь хөгжлийн үнэлгээнд огт хамрагдаж байгаагүй гэсэн судалгаа байна. Үүнтэй харьцуулбал, насанд хүрэгчдийн оношилгоо, үнэлгээний тогтолцоо Монгол Улсад харьцангуй эртнээс бий болсон. Үүнд тухайн хүнд эмчийн анхан шатны үзлэг хийж, улмаар Эмнэлгийн хяналтын комисс оношийг баталгаажуулан, эцсийн шатанд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хяналтанд аймаг дүүргийн түвшинд ажилладаг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах 30 комиссын аль нэг нь шийдвэр гаргадаг байна. Гэхдээ, оношилгоо, үнэлгээ нь гагцхүү анагаах ухааны талаас хийгдэж, эмгэг согогийн ангилалд түшиглэдэг ба нийгэм, эдийн засаг, орчны чухал хүчин зүйлсийг төдийлөн тооцдоггүй.

7. Нийгмийн дэмжих үйлчилгээ, хөгжүүлэх болон сэргээн засах эмчилгээний хүртээмж дутмаг байна. Монгол Улсын хувьд алслагдмал суурьшсан эсвэл бүртгэлд хамрагдаагүй хүн амын бүлгүүдийг тодорхойлох, төрийн үйлчилгээг хүргэхэд тодорхой сорилтуудтай тулгарсаар байна. Үүнд дотоодын шилжилт хөдөлгөөн, хотод бүртгэлгүй шилжин ирэгсэд, хөдөөгийн алслагдмал бүсийн оршин суугчид, хөрөнгө санхүү болон чадавхын хомсдол зэргийг дурдаж болно. Хөгжлийн бэрхшээлийг анагаах ухааны өнцгөөс харж, ХБИ-ийг голлон эмнэлгийн эсвэл асрах байрны нөхцөлд сэргээн засах үйлчилгээгээр хангаж байгаа нь өөрөө хүндрэл бэрхшээлийг үүсгэж байна. Халамжийн тэтгэмж олгохоос бусдаар ХБИ-д нийгмийн цогц үйлчилгээ хүргэж чаддаггүй ба тухайлбал гэрээр сувилах үйлчилгээ хязгаарлагдмал (жилд 15 өдрөөс ихгүй), нийтийн тээврийн зардлыг зөвхөн хэсэгчлэн нөхөн олгодог, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийн олдоц муу, нэр төрөл хэт цөөн зэргийг дурдаж болно. Түүнчлэн, ХБИ-тэй өрхүүдийн 70 хувь нь өөрт хамаарах нийгмийн халамж, тэтгэмж, үйлчилгээний талаар хангалттай мэдээлэл авч байгаагүй гэж судалгаа өгсөн нь мэдээлэл дутагдалтай байгаа бас нэгэн хүндрэл бэрхшээлийг илтгэж байна. ХБИ-ийн 30 хувь нь тусгай хэрэглээний тоног төхөөрөмж ашиглахыг хүсдэг ч ердөө 6 хувьд нь хүрэлцдэг аж. Төрийн бус байгууллагууд (ТББ)-ын оролцоо, дэмжлэгтэйгээр олон нийтэд түшиглэсэн үйлчилгээ аажмаар бий болж байгаа ч санхүүжилт дутагдахын зэрэгцээ голлон нийслэл хотод төвлөрч байна. Нийгмийн халамжийн тогтолцоонд хувиараа дэмжих үйлчилгээ эсвэл гэрээр асрах үйлчилгээ үзүүлэхийг онолын хувьд зөвшөөрсөн боловч хэрэгжүүлэх журам байдаггүй.

8. Боловсролын хүртээмж хангалтгүй байна. ХБХ-ийн ердөө 64 хувь нь сургуульд суралцаж байгаагаас ХБИ-ийн боловсролын хүртээмж сул байгааг харж болно. Монгол Улсад гэрийн сургалтын тусгай боловсрол төдийлөн хөгжөөгүй. Тусгай сургуулиуд зөвхөн Улаанбаатар хотод байдаг ба нийт ХБХ-ийн 20 хувь нь эдгээр сургуульд суралцаж байна. ХБХ-ийг ерөнхий боловсролын ердийн сургуулиудад суралцуулах чиглэлд тодорхой

⁴ Хөгжүүлэх эмчилгээ гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын амьдралд нь шаардлагатай тодорхой үйлдэл чадварыг хөгжүүлэх, хадгалах, сайжруулахад чиглэсэн эмчилгээг хэлнэ. Сэргээн засах эмчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй болсон эсвэл хөгжлийн бэрхшээлийн мөн чанар нь өөрчлөгдсөний улмаас алдагдсан ур чадвар, бие махбодийн чадавх, оюуны мэдлэгийг сэргээхэд чиглэдэг.

Integrating Persons with Disabilities into Mongolia's Society

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах нь

алхмууд хийгдэж эхэлсэн хэдий ч сургуульд ийнхүү хамрагдсан хүүхдүүдийн 70 хувь нь сургуульд хүрэх замдаа саадтай тулгардаг аж. Тухайлбал, тээврийн сонголт байхгүй, асран хамгаалагч нь хүүхдээ сургуульд хүргэх авах боломж муутай, замд ядардаг зэргийг дурдсан байна. 15-аас дээш насны бүлгийн боловсролын түвшинг харвал, таван ХБХ-ийн нэг нь ямар ч боловсрол эзэмшээгүй байхад хөгжлийн бэрхшээлгүй хүн амын хувьд энэ үзүүлэлт 4 хувь байна.

9. **Хөдөлмөр эрхлэлтийн боломж хязгаарлагдмал.** Монгол Улсад ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс ихээхэн доогуур байна. 2014 оны байдлаар 15 ба түүнээс дээш насны ХБИ-ийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх түвшин 25.2 хувь байсан бол нийт хүн амын хувьд энэ үзүүлэлт 62.1 хувь байжээ. Хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр авч үзэхэд ХБИ ба бусад хүн амын хооронд томоохон ялгаа зөрүү байна. Тухайлбал, эдийн засгийн идэвхтэй ХБИ-ийн 45 хувь нь малчин бол нийт хүн амын 25 хувь нь л мал аж ахуй эрхэлж байна. Түүнчлэн, ХБИ-ийн ердөө 22 хувь нь цалинтай ажилтай бол нийт хүн амын хувьд энэ үзүүлэлт 50 хувь байна. ХБИ-ийн сарын дундаж цалин бусад иргэдийн дундаж цалингийн ердөө 50 хувьтай тэнцдэг аж. Оюуны бэрхшээлтэй хэмээн тодорхойлогдсон иргэдийн хувьд асуудал бүр хүндэрнэ. Одоогийн байдлаар, ХБИ-ийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн гол боломж нь хувиараа хөдөлмөр эрхлэх сонголтоор хязгаарлагдаж, хөдөлмөрийн зах зээл дээрх нээлттэй ажлын байр туйлын хомс байна. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулинд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 50-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж ажлын байрныхаа 3-аас доошгүй хувийг ХБИ-д олгохоор заасан хэдий ч энэ шаардлага бүрэн хэрэгждэггүй тул дорвитой үр дүн гарахгүй байна. Дэлхийн зарим улс орон үүнээс өргөн цар хүрээтэй арга хэмжээ авсан байдгаас дурдвал, Швед Улсад ажил олгогчдод цалингийн татаас олгож, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлын байр шинээр бий болгох чиг үүрэг бүхий төрийн байгууллага ажилладаг.

10. **ХБИ-ийн нийгмийн хамгаалал дутмаг байна.** Тэтгэмж, тусламж үйлчилгээг нийгмийн даатгалын шимтгэл болон татварын орлогын эх үүсвэрээс санхүүжүүлдэг. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 80 орчим хувь нь даатгалд хамрагдсан. Нийгмийн даатгалд тахир дутуугийн тэтгэмжийн даатгал багтдаг бөгөөд тэтгэмжийн доод хэмжээг цалингийн доод хэмжээний 75 хувиар тогтоосон. Нийгмийн халамжийн тухай хуулинд ХБИ-д зориулсан нийгмийн тэтгэмжийн бусад төрлүүдийг заасан хэдий ч хүрэлцээ муу байна. Бодит амьдралд одоогийн нийгмийн халамжийн тогтолцоо нь хамрах хүрээ, хүртээмж, уян хатан чанар зэргээс хамааран төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн хувьд алдаа дутагдалтай байна. Хөгжлийн бэрхшээлийн бүртгэгдээгүй, тайланд багтаагүй тохиолдлууд ямар нэгэн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ба бүртгэлтэй ХБИ ч халамжийн тэтгэмжүүдээ бүрэн авч чадахгүй байна. Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоонд дутагдаж байгаа нэг чухал зүйл бол ХБИ-ийн хөгжлийн үнэлгээтэй уялдах холбоос юм. Ийнхүү уялдаатай байвал ХБИ-ийн авч буй тэтгэмж ба үйлчилгээ тэдний онцлог хэрэгцээнд илүү нийцэх болно. Дэлхийн зарим улс оронд ХБИ-ийн шаардлага хэрэгцээг тодорхой түвшнүүдэд

хувааж, илүү өндөр түвшний хэрэгцээнд илүү өндөр дүнтэй мөнгөн тэтгэмж олгох хөгжлийн үнэлгээний тогтолцоо нэвтрүүлээд байна.

11. **ХБИ-ийн амьдрах орчин саад ихтэй байна.** 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд саадгүй орчин бүрдүүлэх тухай зүйл заалтыг тусгаж, ирээдүйн алсын харааг тодорхойлсон. Одоогоор биет орчин, тээвэр, мэдээлэл, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийн саадгүй хүртээмжийн талаар хуулинд тусгасан ч хэрэгжилт бүрэн хэмжээнд хийгдэхгүй, хяналт сул байна. ХБИ-ийн саадгүй оролцоог хангах тал дээр ХБИБ идэвхтэй ажиллаж, хяналт тавих, олон нийтийн кампанит ажил явуулах зэргээр оролцож байна. Швед зэрэг улс орнуудад ХБИБ энэ чиглэлээр маш их үүрэг гүйцэтгэсэн туршлага бий. Тухайлбал тэдний хүчин чармайлтын дүнд ХБИ-ийн тээвэр, хөдөлмөр эрхлэлт, биеийн тамир спортын хүртээмжийг хангах зорилгоор Стокхольм хот даяар томоохон өөрчлөн байгуулалтуудыг хийсэн байна.

III. ЗӨВЛӨМЖ

12. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлийг голлон хөдөлмөр эрхлэх чадварыг алдагдуулах эмгэг согог талаас нь ойлгож байгаа нь ихээхэн сөрөг үр дагавартай юм. Үүнээс улбаалж, ХБИ-ийг нэг бол хөдөлмөрлөх чадваргүй гэж үзэн нийгмийн халамжинд хамрагдах эрхтэй гэж ойлгох, эсвэл хөдөлмөр эрхлэх чадвартай бол ямар нэгэн дэмжлэг тусалцаа шаардлагагүй хэмээн үздэг. Харин нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох боломжийг хязгаарлаж буй орчны саадыг арилгахад бодит хөрөнгө оруулалт хийх нь илүү үр дүнтэй арга бөгөөд улмаар халамж, тэтгэмж, тэтгэврийн шаардлага хэрэгцээг бууруулах сайн талтай байж болно. Түүнчлэн, ХБИ-ийг бусадтай ижил эрх үүрэгтэй хүн болохыг хүлээн зөвшөөрч буй үзэл баримтлалыг амьдралд нэвтрүүлж, тодорхой салбаруудад өөрчлөлт шинэчлэл хийх шаардлагатай юм. Бидний санал болгож буй доорх бодлогын зөвлөмжүүд нь ХБИ-ийн оролцоог бодитоор хангасан нийгмийг цогцлооход нь Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг болох зорилготой юм.

13. **Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, тодорхойлолтыг оновчлох.** 2016 оны хуулинд орсон хөгжлийн бэрхшээлийн тухай тодорхойлолтыг бодлого зохицуулалтын бүх түвшинд нэгдмэл байдлаар нэвтрүүлж, ашигладаг болох шаардлагатай. Олон нийтийн мэдээллийн кампанит ажил, нийгмийн сүлжээний маркетингийн арга хэрэгслийг ашиглан ХБИ-ийн нийгмийн оролцоог хангах тухай үзэл бодлыг түгээн сурталчилснаар аажимдаа нийгмийн сэтгэлгээнд өөрчлөлт ороход дэмжлэг болно. Ингэхдээ оюуны бэрхшээл болон сэтгэцийн эмгэгийн асуудлыг тусгайлан анхаарвал зохино.

14. **Хөгжлийн үнэлгээг сайжруулах.** Хөгжлийн үнэлгээний зохистой тогтолцоог нэвтрүүлснээр бие даан амьдрахыг дэмжих үйлчилгээ, тусгай хэрэглээний тоног төхөөрөмж, хөгжүүлэх болон сэргээн засах эмчилгээ, бусад шаардлагатай нийгмийн үйлчилгээг уян хатнаар үзүүлэх нөхцөл бүрдэж, ХБИ-ийн бие махбодийн үйл ажиллагаа, нийгмийн

Integrating Persons with Disabilities into Mongolia's Society

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах нь

харилцаанд оролцох чадварыг сайжруулж болно. Нийгмийн халамжийг хялбаршуулж, хөгжлийн үнэлгээний дүнд үндэслэн тус тусдаа биш нэгдмэл цогц дэмжлэг үзүүлдэг болвол илүү үр дүнтэй. Хамгийн гол нь насанд хүрэгчид болон хүүхэд тус бүрийн нөхцөл байдлыг бүрэн хэмжээнд авч үзэж, олон талт үнэлгээ хийх шаардлагатай юм. Түүнчлэн, тухайн хүний бие махбодь, оюуны үйл ажиллагаа болон үйлдэл чадвар өөрчлөгдөж байгаа эсэхийг тогтоохын тулд хөгжлийн үнэлгээг ойр ойрхон давтан хийх нь зүйтэй. 2016 оны хуулийн тодорхойлолттой уялдсан, хөгжлийн бэрхшээлийг цогцоор нь үнэлэх нэг аргачлал бол “Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл эрүүл мэндийн олон улсын ангилал” (ICF) юм. Тус аргачлалаар эмгэг согог, хөдөлгөөний саатал, нийгмийн оролцоог хязгаарлах нөхцөл байдлыг бүхэлд нь хөгжлийн бэрхшээл хэмээн тодорхойлж, тухайн хүний үйлдэл чадварт нөлөөлж буй хувь хүний болон орчны (нийгмийн) хүчин зүйлсийг харгалзан авч үздэг. Цаашилбал, аргачлалыг шинэчлэхийн зэрэгцээ ХБХ-ийн эрт оношилгоо, хөгжлийн үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

15. Хүн бүрт тохирсон үйлчилгээгээр дамжуулан нийгмийн оролцоог хангах. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүргэгчдэд хүргэх үйлчилгээ нь анхан шатны оношилгооноос эхлээд насан туршид нь тухайн хүн тус бүрийн онцлог хэрэгцээ шаардлагатай уялдсан байвал зохино. Төрийн болон төрийн бус аль ч байгууллага үйлчилгээ үзүүлж болох юм. Хамгийн гол нь хууль тогтоомжид тодорхой заагдсан өндөр стандартын дагуу үйлчилгээ үзүүлдэг байх нь чухал. Төрийн болон ТББ хамтран үйлчилгээ үзүүлэх нь үйлчилгээний цар хүрээ, агуулгын зохистой байдлыг хангах хамгийн зөв шийдэл байж болох юм. Аль ч тохиолдолд, физик эмчилгээ, сэргээн засах эмчилгээ, хэл ярианы эмчилгээ, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, зохих хөрөнгө дэмжлэгээр хангах нь чухал.

16. Нийгмийн халамж, тэтгэмжийн тогтолцоог шинэчлэх. ХБИ-ийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан олон талт хөгжлийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх нь нийгмийн халамжийн үр дүн, үр нөлөөг сайжруулах үндэс байж болох юм. Ийм тогтолцооны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн тус бүрийн онцлог шаардлага хэрэгцээнд нийцсэн цор ганц тэтгэмжийн багц бий болгох боломжтой юм. Үүний зэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй хүний асран халамжлагчид олгодог тэтгэмжийн тогтолцоог дахин шинэчилж, үнийн дүнг нь нэмэгдүүлэн, шаардлага хэрэгцээнийх нь түвшинтэй уялдуулбал зохино.

17. Дэд бүтэц, тээвэр, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх. Тээврээр үйлчлүүлэх, дэд бүтэц ашиглах, мэдээлэл авахад тулгарч буй биет болон биет бус саадыг багасгах буюу арилгах шаардлагатай бөгөөд үүний тулд хөгжлийн бэрхшээлийн шинэ тодорхойлолтыг бүхий л хууль тогтоомжинд тусган уялдуулах нь зүйтэй. Хэрэгжилтийг ХБИБ-ын дэмжлэгтэйгээр хянаж болох ба тухайн байршлыг хариуцсан ажилтан, албан хаагчдыг сургалтанд хамруулах нь зүйтэй. Төрөөс хангадаг тусгай хэрэглээний тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалтыг үе үе хянан шинэчилж, шинэ технологийн шийдэл болон оюуны бэрхшээл зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог дэмжих хэрэгслүүдийг

нэмж оруулдаг тогтолцоо бүрдүүлбэл зохино. Хуульд тодорхойлсон алсын харааг бүрэн хэрэгжүүлэхийн тулд энэ чиглэлээрх дүрэм журмын хэрэгжилтийг ХБИБ үргэлжлүүлэн хянах нь зүйтэй.

18. Боловсролын хүртээмж, хөдөлмөр эрхлэлтийг өргөжүүлэх. ХБИ хөдөлмөрийн зах зээлд хязгаарлагдмал оролцдог нь тодорхой хэмжээнд боловсролын түвшин доогуур байдагтай нь холбоотой. ХБХ-ийг зохих дэмжлэг тусалцаагүйгээр ердийн ерөнхий боловсролын сургуульд хамруулах нь тэдний оролцоог бүрэн хангаж чадахгүй юм. Иймд, сургалтын хөтөлбөр, заах аргачлал, стратеги зэрэгт зохих өөрчлөлтийг оруулах, багш нарыг хангалттай сургалт, дэмжлэгт хамруулахад чиглэсэн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд сургуулиудад саадгүй орчин бүрдүүлэх хэрэгтэй. Түүнчлэн, ХБИ-д зориулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг тэдний шаардлага хэрэгцээтэй уялдуулан, хөдөлмөрийн зах зээл дээрх нээлттэй ажлын байруудад түлхүү анхаарвал зохино. Ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэхэд эрэлт ба нийлүүлэлт аль аль талаас нь авч үзэх хэрэгтэй ба үүнд хөдөлмөрийн биржийн ажилтнуудыг сургах, ажлын байрны дагалдуулан сургах хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах, нийт ажилчдад эзлэх ХБИ-ийн хувь хэмжээний журмыг нарийн баримтлуулах, ажлын байрны нөхцөлийг хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохируулан өөрчлөхөд санхүүжилт олгох зэрэг арга хэмжээг дурдаж болно.

19. Хяналтыг чангатгах. Хууль эрх зүй, бодлогын санаачлагуудыг боловсруулах, хэрэгжүүлэхийн тулд энэ чиглэлээр тогтмол хангалттай мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх шаардлагатай. Иймд, өрхийн болон бусад судалгааны асуумжид хөгжлийн бэрхшээлийн шинэ тодорхойлолтыг тусгаж, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлийн статистикийн Вашингтоны бүлгээс⁵ гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Улмаар, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зорилгоор холбогдох төрийн байгууллагууд судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж, ажлаа дүгнэх шаардлагатай юм.

⁵ Хөгжлийн бэрхшээлийн статистикийн Вашингтоны бүлэг гэдэг нь НҮБ-ын Статистикийн хорооны харьяанд байгуулагдсан салбарын албан бус зөвлөх байгууллага юм. Дэлхийн хүн амын хөгжлийн бэрхшээлийн статистикийг улс хооронд харьцуулахуйц байдлаар цуглуулдаг болох тулгамдсан шаардлагыг шийдвэрлэхийн тулд байгуулагдсан тус бүлэг нь эрүүл мэндийн статистикийн чиглэлд олон улсын хамтын ажиллагааг дэмжих, уялдаа холбоог хангах чиг үүрэгтэй. Үйл ажиллагаа нь хүн амын тооллого, улс нийтийн судалгаанд ашиглаж болох, хөгжлийн бэрхшээлийн статистикийн мэдээлэл цуглуулах хэрэгслийг боловсруулахад голлон чиглэдэг.

Integrating Persons with Disabilities into Mongolia's Society

In Mongolia, persons with disabilities still face significant challenges in their daily lives despite the adoption of progressive legislation on their rights. More should be done to facilitate their societal integration and meet the aims of the Convention of the Rights of Persons with Disabilities of the United Nations. This brief looks at the current environment in the country for persons with disabilities and presents recent data on their population. Policy recommendations aim to help Mongolia become a more inclusive, barrier-free society for persons with disabilities. Suggested reforms aim for a better understanding and assessment of disabilities to facilitate developments for better access to infrastructure, transport, and information as well as inclusive education and employment.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах нь

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-ийн эрхийн тухай дэвшилттэй хууль батлагдсан хэдий ч Монголд амьдарч буй ХБИ өдөр тутмын амьдралдаа томоохон сорилтуудтай тулгарсаар байна. Монгол Улс НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зорилтуудыг биелүүлж, ХБИ-ийн нийгэм дэх эрх тэгш оролцоог хангахын тулд илүү их хүчин чармайлт гаргах шаардлагатай. Энэхүү товч танилцуулгад ХБИ-ийн одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох статистикийн үзүүлэлтүүдийг танилцуулсан. ХБИ-д ээлтэй, тэдний оролцоог хангасан нийгмийг цогцлооход дэмжлэг үзүүлэх бодлогын зөвлөмжүүдийг санал болгосон. Санал болгож буй арга хэмжээ нь мэдээллийн, тээврийн болон дэд бүтцийн хүртээмжийг сайжруулахын зэрэгцээ боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үүднээс хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, үнэлэмжийг гүнзгийрүүлэхэд чиглэсэн.

About the Asian Development Bank

ADB is committed to achieving a prosperous, inclusive, resilient, and sustainable Asia and the Pacific, while sustaining its efforts to eradicate extreme poverty. Established in 1966, it is owned by 68 members—49 from the region. Its main instruments for helping its developing member countries are policy dialogue, loans, equity investments, guarantees, grants, and technical assistance.

Азийн хөгжлийн банкны тухай

АХБ нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ цэцэглэн хөгжсөн, хүртээмжтэй, тогтвортой, сөрөг нөлөөнд тэсвэртэй бүс нутгийг цогцлоохын төлөө тууштай ажилладаг. Анх 1966 онд байгуулагдсан тус банкны нийт 68 гишүүн орны 49 нь тухайн бүс нутагт оршдог. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, өөрийн хөрөнгийн санхүүжилт, батлан даалт, буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлж байна.



ASIAN DEVELOPMENT BANK

6 ADB Avenue, Mandaluyong City
1550 Metro Manila, Philippines
www.adb.org

Азийн хөгжлийн банк

АХБ-ны өргөн чөлөө-6, Мандалуён хот
Метро Манила 1550, Филиппин Улс
www.adb.org